

“ЭРДЭНЭТ СУВАРГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ



2023 оны 2 дугаар сарын 26-ны өдөр

№ 23/01

Булган хот

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурал 2023 оны 02-р сарын 26-ны өдөр 11.00 цагт хуралдав.

Хуралд оролцсон хүмүүс:

ТУЗ-ын дарга:	О.Маралмаа	<i>О.Маралмаа</i>
ТУЗ-ын гишүүн:	Н. Одонбилэг	<i>Н.Одонбилэг</i>
ТУЗ-ын гишүүн:	Л.Цангилагбар	<i>Л.Цангилагбар</i>
ТУЗ-ын гишүүн:	Б.Батчимэг	<i>Б.Батчимэг</i>
ИК-ын гишүүн:	А.Бадамсүрэн	<i>А.Бадамсүрэн</i>
ТУЗ-ын хараат бус гишүүн:	Л.Гантуяа	<i>Л.Гантуяа</i>
	З.Дэлгэрмаа	<i>З.Дэлгэрмаа</i>

Хувьцаа эзэмшигч:

1. Н. Одонбилэг 133,531 ширхэг хувьцааны

саналын эрхтэйгээр оролцов.

Хурлын тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж компанийн нийт гаргасан 156,054 хувьцаанаас саналын эрхтэй хувьцааны тоог 133,531 ширхэг хувьцаагаар тогтоож, хурлын ирц 85,57 хувьтай байгааг мэдээлж, компанийн тухай хуулийн 69.1 заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлж, болохийг хурлын даргад зөвшөөрөв.

Хурал 11 цаг 00 минутанд эхлэв.

Хурлын дарга Л. Гантуяа хурлыг нээж, хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлуудийг танилцуулав.

Хурлын дэг:

- | | | |
|----------------------------|--------------------|-----------------|
| 1. Хурлын ирцийг бүртгэх. | / Тоологын комисс/ | 10.30-10.50 цаг |
| 2. Хурлын ирцийг мэдээлэх. | / Тоологын комисс/ | 10.50 цаг |



3. Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах. / Хурлын дарга / 11.00 цаг
4. Хурлаар хэлэлцэх асуудалыг дараалалын дагуу уншиж танилцуулах. Үүнд: а/
 - ✓ Компанийн санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт болон ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.
 - ✓ Ноогдол ашиг хувиарлах тухай ТУЗ-ын гаргасан шийдвэрийг батлах.
 - ✓ Компанийн 2023 оны бизнес, үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.
 - ✓ Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах.
 - ✓ ТУЗ-ын дарга болон ТУЗ –ийн гишүүдийг сонгох.
 - ✓ ТУЗ-ын дарга болон ТУЗ –ийн гишүүдийн урамшууллын хэмжээг тогтоох.
 - ✓ Компанийн хувьцааг хуваах төслийг хэлэлцэн батлах

5. Асуулт хариулт, санал шүүмжлэл тавих. / нэг хүн үг хэлэх хугацаа 10 минут /
6. Хурлын завсарлага.
7. Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах. / Тоологын комисс /
8. Хурлаас гаргах шийдвэр, тогтоолыг танилцуулах. / Хурлын дарга /
9. Хурлыг хаах. / Хурлын дарга /

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

Компанийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 12-ны өдрийн 02 тоот тогтоолын дагуу тус тус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

1. Компанийн санхүүгийн тайлангийн түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт болон ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Ноогдол ашиг хувиарлах тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн батлах.
3. Компанийн 2022 оны бизнес, үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.
4. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг төлөвлөгөөг хэлэлцэн, батлах.
5. ТУЗ-ын дарга болон ТУЗ –ийн гишүүдийг сонгох.
6. ТУЗ-ын дарга болон ТУЗ –ийн гишүүдийн урамшууллын хэмжээг тогтоох.
7. Компанийн хувьцааг хуваах төслийг хэлэлцэн батлах

Гүйцэтгэх захирал Н.Одонбилэг: Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон 2023 оны бизнес төлөвлөгөөний талаар уншиж, танилцуулав. /Тайлан хурлын материалд /



Б.Батчимэг: Компанийн 2022 оны санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт болон хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хувиарлах тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийн талаар танилцуулав.

Хурлын дарга Л. Гантуяа хурлаар хэлэлцэх асуудлуудыг дэс дарааллын дагуу уншиж, танилцуулав.

Асуулт, хариулт :

З.Дэлгэрмаа: - Компани 2022 онд ашигтай ажиллаж, 3 жил дараалан ногдол ашиг тарааж байгаад хувьцаа эзэмшигчдийн өмнөөс талархаж байна.

Н. Баярмаа: - Баярлалаа.

Л. Гантуяа: - Хувьцаа эзэмшигчидээ өөр асуух зүйл байна уу.

З.Дэлгэрмаа: Компанийн нэгж хувьцааг хуваасанаар хувьцаа эзэмшигчдэд ямар ашигтай вэ.

Л. Гантуяа: Компани нь хувьцаагаа 1/214 хуваасанаар хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьд өөрчлөлт орохгүйгээр, нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн өгөөж нэмэгдэж, бирж хувьцааны хөрвөх чадвар нь сайжирна.

Л. Гантуяа: - Хувьцаа эзэмшигч болон гишүүдээс оор асуух зүйл байна уу. Байхгүй бол саналаа өгөөд түр завсарлана уу.

Асуулт хариултын цаг дуусч тоологын комисст саналын хуудасаа өгөөд хувьцаа эзэмшигчид түр завсарлав.

Тооллогын комисс саналын хуудасны дүнг нэгтгэн танилцуулав.

Л.Гантуяа: - Нийт 156,054 ширхэг хувьцааны саналын эрхтэй 7 хувьцаа эзэмшигч хуралд оролцохоос биечлэн ирсэн 1 хувьцаа эзэмшигч саналаа өгч, нийт дүнгээр 1 хувьцаа эзэмшигчийн саналыг нэгтгэллээ.

Үүнд:

Санхүүгийн тайлан	зөвшөөрсөн 85,57 хувь ,	татгалзсан 0 хувь
Үйл ажиллагааны тайлан	зөвшөөрсөн 85,57 хувь ,	татгалзсан 0 хувь
Ногдол ашиг хувиарлах тухай	зөвшөөрсөн 85,57 хувь ,	татгалзсан 0 хувь
Үйл ажиллагааны төлөвлөгөө	зөвшөөрсөн 85,57 хувь ,	татгалзсан 0 хувь
ТУЗ-д нэр дэвшүүлэх тухай	зөвшөөрсөн 85,57 хувь ,	татгалзсан 0 хувь



- Ердийн нэр дэвшигч дэвшүүлэх
- Хараат бус гишүүд дэвшүүлэх

ТУЗ –ийн гишүүдийн урамшуулал зөвшөөрсөн 85,57 хувь, татгалзсан 0 хувь

Компанийн хувьцааг хуваах төслийг хэлэлцэн батлах зөвшөөрсөн 85,57 хувь, татгалзсан 0 хувь

Хурлын дарга Л. Гантуяа ХЭЭХурлаас гарсан ХЭЭХ-ийн тогтоолуудын уншиж, ташилцууллаа.

Шийдвэрлэсэн нь:

1. Компанийн санхүүгийн тайлангийн түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт болон ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт болон тайлангуудыг холбогдох цахим хуудсанд тогтмол байршуулах, цаашид компанийн бизнес төлөвлөгөөний дагуу ажиллахыг гүйцэтгэх захирал /Н.Одонбилэг/-т даалгасугай.
3. Компани нь 2022 онд ногдол ашиг хувиарлах шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
4. Компанийн ТУЗ болон хараат бус гишүүдийн дараах бүрэлдхүүнтэйгээр сонгосугай:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд:

1. О.Маралмаа
2. Н.Одонбилэг
3. Ж.Жадамба
4. Б.Батчимэг
5. Х.Гончигсүрэн
6. Л.Цангилагбар

ТУЗ-ын хараат бус гишүүдэд:

1. Л.Гантуяа
2. З.Дэлгэрмаа
3. Ц.Сайнжаргал

ТУЗ-ын даргаар О.Маралмаа-г сонгов.



5. ТУЗ-ын болон Хараат бус гишүүдийн 2022 оны урамшууллын дүнг нэг гишүүнийн 300 000 /гурван зуун мянган/ төгрөгөөр тогтоосугай.
6. Компанийн хувьцааг хуваах төслийг хэлэлцэн, компанийн нийт гаргасан 156054 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийн 214 хувааж, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 33 395 556 ширхэг энгийн хувьцаа болгон хуваасугай.
7. “Эрдэнэт суварга” ХК-ийн хувьцаа хуваах төслийг энэ тогтоолын 1-р хавсралтаар баталсугай.
8. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан компанийн нэрлэсэн үнэ, тоо өөрчлөгдөж компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлтийг оруулан, өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, холбогдох зөвшөөрөл авах ажлыг зохион байгуулахыг гүйцэтгэх захирал /Н.Одонбилэг/-т даалгасугай.

Хурлын дарга хурлыг хааж, үг хэлсэнээр Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал 12.12 цагт өндөрлөв.

Хурал удирдсан:

Хурлын дарга



/Л.Гантуяа/